

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн  
байнгын хорооны 2026 оны ... дугаар  
сарын ... -ны өдрийн ..... дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

## ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

**Товч удирдамж:** Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв, бүрэн дүүрэн бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралтыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ. Мөн, нэр дэвших тухай хүсэлтийг Word-ын файлаар цахим шуудан /сонгон шалгаруулах тухай зард заасан хаяг/-аар тус Байнгын хороонд явуулна.

### НЭГ. ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

1.1	<b>Эцэг/эхийн нэр:</b> Галбаабадраа. .... <b>Ургийн овог:</b> . Шошоолог. .... <b>Нэр:</b> ..... Даваадалай. .... <b>Хүйс:</b> ..... Эр ..... <b>Төрсөн он:</b> . 1979 ..... <b>Төрсөн газар:</b> Хөвсгөл аймаг, Хатгал . . . <b>Одоо оршин суугаа аймаг/нийслэл, сум/дүүрэг:</b> Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, [REDACTED] [REDACTED]
1.2	<b>Иргэний харьяалал</b> Монгол Улсын иргэн мөн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. .....Тийм.....
1.3	<b>Насны дээд хязгаар</b> Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/. .....Үгүй.....
1.4	<b>Шүүгчийн албан тушаал</b> Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, аль шүүхэд ямар хугацаанд шүүгчээр ажиллаж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. .....Үгүй.....
1.5	<b>Улс төрийн болон намын удирдах албан тушаал</b> Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/. .....Үгүй.....
1.6	<b>Эрүүгийн хариуцлага</b> Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.

	Үгүй, ЦЕГ-ын тодорхойлолт хавсаргав
1.7	<p><b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн</b> Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....Үгүй.....</p>
1.8	<p><b>Монгол Улсын Их Хурлаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилохоос татгалзаж байсан</b> Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн боловч Монгол Улсын Их Хурлаас томилохоос татгалзаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/.</p> <p>Үгүй, 2025 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшиж Улсын Их Хурлаас байгуулагдсан Ажлын хэсгийн ярилцлагад орж байсан.</p>

## **ХОЁР.ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР**

2.1	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/</p> <p>Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Шүүхийн тухай хуульд зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хуульчдаас шүүгчийг шилж сонгон шалгаруулах, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг бүхий шүүхийн захиргааны байгууллага мөн. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 33 дугаар тогтоолоор “Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого”-ын баримт бичгийг баталж, шүүх эрх мэдлийн цаашдын хөгжлийн суурь бодлого, зорилтыг тодорхойлсон.</p> <p>Миний бие Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон, “Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого”-д туссан дараах зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэрээ дэвшүүлж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шүүхэд мэдүүлэх иргэний эрхийн баталгааг хангаж, шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх;</li> <li>2. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хариуцлагатай шүүхийг төлөвшүүлэх;</li> <li>3. Шүүх эрх мэдлийн байгууллагын захиргааны менежментийг боловсронгуй болгон хөгжүүлэх;</li> <li>4. Шүүхийн хүний нөөцийн чадавхыг хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тасралтгүй хөгжүүлэх;</li> <li>5. Шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;</li> <li>6. Шүүхийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх;</li> </ol>
-----	--

7. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нийцсэн, тогтвортой, урьдчилан тооцоолох боломжтой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах.

Түүнчлэн, шүүхийн шинэтгэлийн бодлогын залгамж чанарыг хадгалж, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2021–2026 онд хэрэгжүүлсэн үр дүнтэй ажил, ололт амжилтыг үргэлжлүүлэн бэхжүүлэхийн төлөө төрийн захиргааны чиглэлээр хуримтлуулсан өөрийн туршлага, мэргэшил, мэдлэг, ур чадварт тулгуурлан ажиллахаа илэрхийлж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг эрх зүйн болон институцийн түвшинд бэхжүүлэх чиглэлээр тодорхой ахиц гарсан хэдий ч практик хэрэгжилтийн түвшинд анхаарах шаардлагатай асуудлууд байсаар байна.

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон шинэчилсэн найруулгаар батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар:

- шүүгчийг сонгон шалгаруулах тогтолцоог боловсронгуй болгох;
  - шүүхийн захиргааны бие даасан байдлыг нэмэгдүүлэх;
  - шүүхийн сахилга, хариуцлагын тогтолцоог шинэчлэх;
  - шүүхийн төсөв, санхүүгийн баталгааг сайжруулах;
  - шүүхийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх
- чиглэлээр өмнөх үеэс илүү тодорхой эрх зүйн зохицуулалтыг бий болгосон нь шүүхийн бие даасан байдлын баталгааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Гэвч практикт шүүх эрх мэдэлд улс төр болон олон нийтийн зүгээс үзүүлэх дарамт, нөлөөллийн эрсдэл бүрэн арилаагүй, түүнчлэн шүүхийн санхүү, хүний нөөц, дэд бүтцийн чадавхын ялгаа хэвээр байгаа нь шүүхийн бие даасан байдлыг бодит утгаар хэрэгжүүлэхэд тодорхой хүндрэл учруулж байна.

Мөн шүүхэд итгэх олон нийтийн итгэл тогтвортой өндөр түвшинд хүрээгүй байгаа нь зөвхөн шүүн таслах ажиллагааны чанартай холбоотой бус, шүүхийн байгууллагын ил тод байдал, ёс зүй, хариуцлага, байгууллагын менежменттэй шууд холбоотой асуудал хэвээр байгааг харуулж байна.

Иймд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын эрх зүйн орчин, институцийн тогтолцоо өмнөх жилүүдтэй харьцуулахад тодорхой ахицтай болсон боловч эдгээр зарчмыг бодит амьдрал дээр бүрэн хэрэгжүүлэх, олон нийтийн итгэлийг бэхжүүлэх, эдийн засаг болон захиргааны баталгааг улам боловсронгуй болгох шаардлага цаашид хэвээр байна гэж үзэж байна.

Тухалбал:

1. Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангах үндсэн нөхцөлийн нэг нь шүүхийн хүний нөөцийн тогтвортой, чанартай тогтолцоог бүрдүүлэх явдал мөн. Өнөөгийн нөхцөлд шилдэг хуульчдыг шүүгчийн албан тушаалд татан оролцуулах, тогтвор суурьшилтай

ажиллах нөхцөл, хөгжлийн боломжийг нэмэгдүүлэх бодлогын хэрэгцээ өндөр байна.

Иймд шүүгчийн сонгон шалгаруулалт, бэлтгэл, хүний нөөцийн төлөвлөлтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хууль санаачлагчидтай хамтран ажиллах, хуульчдыг урт хугацаанд шүүгчээр бэлтгэх бодлого хэрэгжүүлэх, шүүхийн хүний нөөцийн сургалт, хөгжлийн тогтолцоог боловсронгуй болгоход анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

2. Шүүхийн хараат бус, бие даасан байдлын үндсэн баталгааны нэг нь санхүүгийн хараат бус байдал юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүх үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана” гэж заасан нь төрийн эрх мэдэл хуваарилах зарчимд нийцсэн төрийн үүргийг тодорхойлсон зохицуулалт юм.

Шүүх бүр хуульд заасан чиг үүргээ бие даан хэрэгжүүлэх онцлогтой тул шүүхийн санхүүгийн баталгаа нь шүүгчийн хараат бус байдлыг хангах, улмаар иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг хамгаалах суурь нөхцөл болдог. Иймээс шүүхийн үйл ажиллагаанд шаардлагатай төсөв, санхүүжилтийг улсын төсөвт бодит хэрэгцээнд нийцүүлэн бүрэн тусгуулах, шүүхийг зориулалтын байр, шүүгчийн болон шүүхийн захиргааны ажилтны ажлын ачааллыг зохист түвшинд байлгах, тэдгээрийн цалин хөлс, нийгмийн баталгааг хангах чиглэлээр идэвх санаачилгатай, үр нөлөөтэй ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

3. Сүүлийн жилүүдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор шүүхийн байгууллагыг бүхэлд нь үгүйсгэн харлуулах, шүүхийн шийдвэрийн агуулгыг мушгин гуйвуулах, нийгмийн сүлжээгээр нэг талыг барьсан, сөрөг мэдээлэл түгээх хандлага нэмэгдэж байна. Энэ нь шүүгчийн хараат бусаар ажиллах нөхцөлд сөргөөр нөлөөлж, сэтгэл зүйн дарамт, мэргэжлийн стресс үүсгэх эрсдэлийг бий болгож байна.

Хэдийгээр шүүх нь олон нийтийн хүлээлтэд бус, зөвхөн хуульд захирагдан шийдвэр гаргах ёстой боловч иргэдийг бодитой, ойлгомжтой мэдээллээр хангах, шүүхийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ажлын ачааллыг бууруулахад шүүхийн цахимжилтыг эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Үүнтэй зэрэгцэн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудад зөвхөн мэргэжлийн сургалт бус, мэдээллийн технологи, харилцаа, сэтгэл зүй, стресс менежментийн чиглэлээр цогц сургалт, зөвлөгөө үзүүлэх тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай байна. Энэ нь нийгмийн орчны зүгээс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, шүүгчийн мэргэжлийн бие даасан байдлыг хамгаалах чухал нөхцөл болно гэж үзэж байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн хувьд эдгээр баталгааг бодитой хэрэгжүүлэхэд хамтын зарчмаар ажиллах болно.

## ГУРАВ.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
3.1	<p data-bbox="331 271 986 304"><b>Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал</b></p> <p data-bbox="331 304 1473 450">Хүсэлт гаргагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан байдлын талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul data-bbox="435 450 1473 633" style="list-style-type: none"><li>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;</li><li>-ажлын байрны тодорхойлолтын гол агуулга;</li><li>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;</li><li>-тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/.</li></ul> <p data-bbox="331 745 355 779">1.</p> <ul data-bbox="371 779 1473 1003" style="list-style-type: none"><li>- 2025 оноос Монгол Улсын Үндсэн хуулийн Тамгын газрын дэд дарга бөгөөд Захиргаа, удирдлагын газрын дарга,</li><li>- 2015 оноос Үндсэн хуулийн цэцийн Тамгын газарт Газрын дарга,</li><li>- 2014- 2015 Үндсэн хуулийн цэцийн Тамгын газарт хэлтсийн дарга,</li></ul> <p data-bbox="371 925 1425 1003">Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Зайсангийн гудамж - Үндсэн хуулийн цэцийн ордон</p> <p data-bbox="371 1037 1473 1220"><b>Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга:</b> Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бие даасан, хараат бус байдлыг хангах, тамгын газрын захиргаа, төрийн албан хаагчдын хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгааг бүрдүүлэх, хөдөлмөрийн харилцааг зохицуулах, Үндсэн хуулийн цэцийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн хэрэгжилтийг хангуулах,</p> <p data-bbox="435 1220 699 1254">Дээрх хугацаанд:</p> <ul data-bbox="355 1254 1473 1753" style="list-style-type: none"><li>• Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга асан Н.Чинбат, утас: [redacted]</li><li>• Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан Д.Наранчимэг, [redacted]</li><li>• Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, утас: [redacted]</li><li>• МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, хууль зүйн доктор С.Сүхчулуун, утас: [redacted] <a href="mailto:Sukhchuluun.s@num.edu.mn">Sukhchuluun.s@num.edu.mn</a></li><li>• Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн багш Н.Болортунгалаг, утас: [redacted] <a href="mailto:bolortungalag@naog.gov.mn">Bolortungalag@naog.gov.mn</a> нартай хамтран ажиллаж байсан.</li><li>• Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын ахлах мэргэжилтэн Д.Дуламсүрэн, [redacted]</li></ul> <ul data-bbox="371 1821 1473 1888" style="list-style-type: none"><li>- 2012 оны 12 дугаар сараас Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар Судалгаа хариуцсан Ахлах зөвлөх,</li></ul> <p data-bbox="371 1888 1425 1966">Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, [redacted]</p> <p data-bbox="371 2011 1473 2076"><b>Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга:</b> Монгол Улсын Үндсэн хуулийг сурталчлан, таниулах зорилгоор гадаадын адил чиг үүрэг бүхий</p>

(Судалгаа хөгжлийн газар, Венецийн комиссын КОДИСЕС систем, Үндсэн хуулийн шүүх түүнтэй адилтгах байгууллагуудын Азийн нийгэмлэгийн судалгаа хөгжлийн газар зэрэг газруудтай судалгаа, мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллахаас гадна Үндсэн хуулийн цэцээс болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулдаг арга хэмжээ (эрдэм шинжилгээний хурал, уралдаан, тэмцээн) зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, Бусад улсын Үндсэн хуулийн шүүх, түүнтэй адилтгах байгууллага, Олон улсын болоод бүс нутгийн шүүх, НҮБ-ын гэрээний хороо болон бусад холбогдох байгууллагууд ижил төстэй маргаан шийдвэрлэсэн байдлыг судлах, Тамгын газрын ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг төлөвлөн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

Дээрх хугацаанд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Ч.Дашням, утас: 99094584,
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан Д.Наранчимэг, утас: 99157631,
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан Д.Мөнхгэрэл, утас: 99164105
- Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын хууль зүйн асуудал эрхэлсэн ахлах зөвлөх Н.Болортунгалаг, утас: 99018889,
- Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын шинжээч Н.Соронзонболд, утас: 99106651 нартай хамтран ажиллаж байсан.

- 2012 оны 4 дүгээр сараас Үндсэн хуулийн цэцийн гишүүний туслах-Тамгын газрын Ахлах мэргэжилтэн

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Зайсангийн гудамж, Үндсэн хуулийн цэцийн ордон

**Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга:** Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу Цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдлыг урьдчилан шалгах хүрээнд холбогдох судалгаа хийх, Цэцийн гишүүний тогтоол, бага, дунд, их суудлын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэх, шийдвэрийн төсөлд санал боловсруулах, шийдвэрийг ёсчлох, хүргүүлэх, тайлагнах, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг тухай хууль тогтоомжийн хүрээнд явуулахад Үндсэн хуулийн цэцийн гишүүнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх,

Дээрх хугацаанд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Жанцан, [redacted]
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Наранчимэг, утас: [redacted]
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Ч.Дашням, утас: [redacted]
- Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын ахлах зөвлөх Р.Анар, утас: [redacted].
- Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын ахлах мэргэжилтэн Д.Дуламсүрэн, утас: [redacted]

4. 2011-2012 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Гэрээт ажилтан - мэргэжилтэн

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, [REDACTED]

**Ажлын байрны тодорхойлолтын гол агуулга:** Монгол Улсын Засгийн газраас нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтийг хангуулахад Яамны харьяа байгууллагууд болон орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах, Бодлогын хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээ боловсруулах, удирдлагад танилцуулах, салбарт хэрэгжиж буй бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт гаргахад дэмжлэг үзүүлэх.

Дээрх хугацаанд:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн, утас: [REDACTED]
- ЗГХЭГ-ын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, утас: [REDACTED]
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Хэлтсийн дарга С.Дамбий, [REDACTED]
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны мэргэжилтэн А.Мөнхбат, [REDACTED]
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны ахлах мэргэжилтэн Ц.Энхтуяа, [REDACTED]

### 3.2 Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил

Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Ингэхдээ ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.

- 2000 - 2002 онд Зүүн хүрээ коллеж, Дашчойлин хийд. Буддын гүн ухаан, Төвд хэл, нэр орчуулгын багш, Удирдах албан тушаалтан: Тамгын дарга Ц.Алтанхүү, [REDACTED]
- 2002 - 2003 онд Уламжлалт анагаах ухаан, эм зүйн “Монос” дээд сургууль Буддын гүн ухаан, Төвд хэлний багш, Удирдах албан тушаалтан: Захирал Б.Саранцэцэг, [REDACTED]
- 2010 - 2011 онд Зүүн хүрээ коллеж, Дашчойлин хийд. Багш, Хуулийн асуудал хариуцсан ажилтан. Удирдах албан тушаалтан: Тамгын дарга Ц.Алтанхүү, Утас: [REDACTED]

### 3.3 Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар

Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн, эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагын гишүүн бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана.

-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.

-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаал, гүйцэтгэсэн чиг үүргийн нэр, огноог хамгийн сүүлийнхээс нь эхлэн он

дарааллаар бичнэ.
Монголын хуульчдын холбооны гишүүн 2015 онд болсон. Үндсэн хуулийн эрх зүй болон Захиргааны эрх зүйн хорооны гишүүн, Төрийн захиргааны албанд ажиллаж буйтай холбогдуулан 2018 онд гишүүнчлэлийг түр түдгэлзүүлсэн. <b>Хуульчийн гэрчилгээний дугаар № 5164</b>

## ДӨРӨВ.ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ

<b>4.1</b>	<p><b>Хууль зүйн өндөр мэргэшил</b></p> <p>Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг заавал бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;</li> <li>-үйл ажиллагааны гол агуулга;</li> <li>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;</li> <li>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;</li> <li>-тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;</li> <li>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</li> </ul> <p>1. Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлд зааснаар Төсвийн ерөнхийлөн захирагч үйл ажиллагааны Стратеги төлөвлөгөөтэй байхаар заасан бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Монгол Улсын Үндсэн хуулийн стратеги батлах тухай” 28 дугаар тушаалаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн стратеги 2,0 (2025-2028)-ийг баталсан. Энэхүү бодлогын баримт бичигт Үндсэн хуулийн цэцийн алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд 5 зорилтын хүрээнд 25 арга замаар нийт 108 шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон. Уг стратегийг хэрэгжүүлснээр Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байдлын баталгааг бүрдүүлэх маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, шийдвэрийн үндэслэлийг чанаржуулах, төвийг сахисан, ил тод байдлыг хангах, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, инновац, технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх ажлын бүтээмж, хүртээмжийг дээшлүүлэх үр дүнд хүрэх бөгөөд энэхүү бодлогын баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажилласан.</p> <p>2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн шүүх, түүнтэй адилтгах байгууллагуудын Азийн нийгэмлэгийг 2021-2023 онд амжилттай даргалсан бөгөөд энэ нь дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, улмаар Монгол Улсын нэр хүндийг өргөхөд ихээхэн ач холбогдолтой үйл явдал болсон. Уг нийгэмлэгийг даргалах хугацаанд “Улаанбаатарын тунхаглал”-ыг батлан гаргасан ба нийгэмлэгийг даргалагчид дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй “Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газрын матриц бүтэц”-ийн нэгжийн даргаар ажилласан. Тус нийгэмлэг нь бүс нутагт Үндсэн хуульт ёс, хүний эрх, ардчилал, Үндсэн хуулийн шүүхийг бэхжүүлэхэд гол чиг үүргийг гүйцэтгэдэг байгууллага.</p>
------------	--

Түүнчлэн Азийн нийгэмлэгийн даргалагчийн тугийг Тайландын хаант улсын Үндсэн хуулийн шүүхэд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэсэн.

3. Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын Ёс зүйн зөвлөлийн даргаар 2021-2023 онд ажиллах хугацаандаа төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтыг зохион байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, чиг үүргийг амжилттай хэрэгжүүлсэн.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бие даасан, хараат бус байдлыг хангах тухайд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-тай хамтран Монгол Улсад хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх зорилготой “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд цахим шүүхийн үйлчилгээний тогтолцоо бий болгох” төслийн баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн бэлтгэх, хэрэгжүүлэх явцад гүйцэтгэлийн хяналтыг тавьж, төслийн хүрээнд Үндсэн хуулийн цэцийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, Үндсэн хуулийн цэцийн сервер, цахилгаан хангамжийн нэмэлт үүсвэр болох дизель генераторыг тавиулах ажлыг зохион байгуулж, төслийг үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлсэн. (2017-2019)

5. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” 43 дугаар тогтоол, Монгол Улсын Үндсэн хуулийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах хүрээнд 1924 оны Үндсэн хууль, “Бодоогийн Үндсэн хуулийн төсөл”, “Жамсрангийн Цэвээний үндсэн хуулийн төсөл”, 1940, 1960 оны Үндсэн хуулийг архивын ерөнхий газраас хуулбарлах, Мөн 1992 оны Үндсэн хуулийг бүтээлгэж Үндсэн хуулийн музейд залж олон нийтийн хүртээл болгосон. Мөн түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн хамгийн том хувилбараар монгол бичигт хөрвүүлсэн дэлгэмэл хувилбарыг (200x150см) бүтээлцэхэд оролцсон. Түүнчлэн БНТУ, БНЭУ, АНУ, БНФУ, Тайландын хаант улсад суугаа Монгол Улсын элчин сайдын яаманд 90x60см хэмжээ бүхий монгол бичгээр бүтээсэн Үндсэн хуулийг захилгаар бүтээсэн.

6. Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд 1992-2023 оны хооронд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуримтлагдсан хэргийн материал, шийдвэрээр цахим сан үүсгэх ажлыг эхлүүлж, төрийн албан хэрэг хөтлөлт, архивын стандарт нормын дагуу цахим архивын санг бүрдүүлэх, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг кодификацичлах ажлыг зохион байгуулсан.

7. 2014-2025 онд: Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байдлыг хангах хүрээнд хэд хэдэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл, үзэл баримтлалын төслийн саналыг боловсруулж хууль санаачлагчдад холбогдох журмын дагуу уламжлан батлуулахад ажлын хэсгийн гишүүнээр оролцсон байна.

УИХ-ын 2023 оны Зарим байгууллагын цалингийн хэмжээг тогтоох тухай 117 дугаар тогтоол 1, 2 дугаар хавсралт

<https://legalinfo.mn/mn/detail?Lawid=16389637580171&showtype=1> ,

УИХ-ын 2023 оны 117 дугаар тогтоол 2 дугаар хавсралт Үндсэн хуулийн цэцийн гишүүнд олгох төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17048052175391&showType=1>

УИХ-ын 2021 оны Үндсэн хуулийн цэцийн гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай 71 дүгээр тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230710518631>,

УИХ-ын 2025 оны 11 дүгээр тогтоол "Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолд өөрчлөлт оруулах тухай <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355748097741>,

УИХ-ын 2021 оны 73 дугаар тогтоол Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230710559321>,

УИХ-ын 2025 оны 24 дүгээр тогтоол "Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355756078211>

Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 6 дугаар дүгнэлт "Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай"

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=9613>

УИХ-ын 2021 оны Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 69 дүгээр тогтоол "Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай" <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389637485741&showType=1>

8. 2012 – 2014 онд: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Монгол Улсын Үндсэн хууль, бусад холбогдох хуульд заасан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд Үндсэн хуулийн цэцийн гишүүнд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх, холбогдох судалгаа, лавлагаа хийх зэргээр мэргэжил, арга зүйн дэмжлэгийг хууль зүйн өндөр түвшинд үзүүлж байсан бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоол, Үндсэн хуулийн цэцийн магадлал, Дүгнэлт, Тогтоол зэрэг эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, албажуулах зэрэг ажилд оролцож байсан.

9. Монгол Улсын Үндсэн хуулийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах болон Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг сурталчлах хүрээнд 2022 онд "Алганд багтсан эх орон" цуврал нэвтрүүлгийн Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар бүлэг "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц", хэсгийг МҮОНТелевизээр бэлтгэн гаргах, "Монгол Улсын Үндсэн хуулийн хөгжлийн товчоон" баримтат кино, 2020 онд "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" зэрэг баримтат киног бүтээлцэхэд уг контентын агуулгыг хянах зэргээр хамтран оролцсон.

10. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) цахим хуудаст Үндсэн хуулийн цэцийн 310 гаруй шийдвэрийг оруулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналт тавих ажлыг зохион байгуулж байна.

11. Үндсэн хуулийн цэц ба Швейцарын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран "Үндсэн хуулийн шүүхийн шинэтгэл ба ардчилал хүний эрх" төслийг 2024-2026 онд хэрэгжүүлэх хүрээнд төслийн баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн бэлтгэж, 2024 онд төслийг эхлүүлсэн.

❖ Холбоо барих албан тушаалтан:

- Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга асан Д.Баянбилэг, [REDACTED]
- Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын мэдээллийн технологийн газрын дарга асан, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Н.Соронзонболд, [REDACTED]

	<ul style="list-style-type: none"> <li>• Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын Хууль зүйн газрын дарга асан, Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн багш Н.Болортунгалаг, <a href="mailto:bolortungalag@naog.gov.mn">Bolortungalag@naog.gov.mn</a></li> <li>• Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын ахлах зөвлөх Р.Анар, Утас: <a href="mailto:anartsets@gmail.com">anartsets@gmail.com</a></li> <li>• Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын судалгааны төвийн захирал асан, Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч Р.Мухийт, [REDACTED]</li> </ul>
4.2	<p><b>Байгаа бол хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</b></p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх цахим холбоосыг тусгана.</p> <ul style="list-style-type: none"> <li>• “Бяраагийн Чимидийн уншлага: Сонгуульд суралцахуй,” 2025 он номыг бүтээхэд техник багт хамтран оролцсон (248 хуудас)</li> <li>• “Монгол Улсын Үндсэн хууль” 2015 он, Эмхэтгэл, криллээс монгол бичиг рүү хөрвүүлэх ажилд хамтран оролцсон. (158 хуудас)</li> <li>• “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц–30 жил, Түүх, гэрэл зургийн товчоон” 2022 он, эмхэтгэлд хамтран оролцсон. (288 хуудас)</li> <li>• “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр” 5 дугаар боть (358 хуудас), 6 дугаар боть (424 хуудас), 2017 он, 7 дугаар боть 2026 он техник редактор,</li> <li>• Монгол ганжуурын 30 боть, Монгол данжуурын 100 боть, 2010-2020 он “Монгол Ганжуур-Данжуур” төсөл. Цогт цагийн хүрдэн соёлын төвөөс эрхэлсэн энэхүү төслийн хүрээнд Монгол бичгээс крилл бичигт хөрвүүлэх ажилд хамтран оролцсон.</li> <li>• 2014-2025 онд: Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байдлыг хангах хүрээнд Улсын Их Хурлын хэд хэдэн тогтоолын төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулж хууль санаачлагчдад холбогдох журмын дагуу уламжлан батлуулахад оролцсон байна. УИХ-ын 2023 оны Зарим байгууллагын цалингийн хэмжээг тогтоох тухай 117 дугаар тогтоол 1, 2 дугаар хавсралт <a href="https://legalinfo.mn/mn/detail?Lawid=16389637580171&amp;showtype=1">https://legalinfo.mn/mn/detail?Lawid=16389637580171&amp;showtype=1</a> , УИХ-ын 2023 оны 117 дугаар тогтоол 2 дугаар хавсралт Үндсэн хуулийн цэцийн гишүүнд олгох төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл <a href="https://legalinfo.mn/mn/detail?lawId=17048052175391&amp;showType=1">https://legalinfo.mn/mn/detail?lawId=17048052175391&amp;showType=1</a></li> </ul>

	<p>УИХ-ын 2021 оны Үндсэн хуулийн цэцийн гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай 71 дүгээр тогтоол, <a href="https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230710518631">https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230710518631</a>,</p> <p>УИХ-ын 2025 оны 11 дүгээр тогтоол "Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолд өөрчлөлт оруулах тухай <a href="https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355748097741">https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355748097741</a>,</p> <p>УИХ-ын 2021 оны 73 дугаар тогтоол Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай <a href="https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230710559321">https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230710559321</a> ,</p> <p>УИХ-ын 2025 оны 24 дүгээр тогтоол "Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай <a href="https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355756078211">https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355756078211</a></p> <p>Үндсэн хуулийн цэцийн 2013 оны 6 дугаар дүгнэлт "Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" <a href="https://legalinfo.mn/mn/detail?lawId=9613">https://legalinfo.mn/mn/detail?lawId=9613</a></p> <p>УИХ-ын 2021 оны Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 69 дүгээр тогтоол "Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай" <a href="https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389637485741&amp;showType=1">https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389637485741&amp;showType=1</a></p> <p>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Стратеги 2.0 (2025-2028), Үндсэн хуулийн цэцийн Тамгын газарт мөрдөгдөж буй Хөдөлмөрийн дотоод журам, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дүрэм, Судалгааны төвийн дүрэм, Үндсэн хуулийн цэцийн хуралдааны аюулгүй ажиллагааны хангах түр журам, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн журам гэх мэт эрх зүйн баримт бичгийг боловсруулсан.</p>
<p><b>4.3</b></p>	<p><b>Байгаа бол Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (гэрчилгээ)</b></p> <p>Хуульчийн мэргэжлийн, эсхүл өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрөлтэй юу, эсхүл ийм зөвшөөрөлтэй байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, уг зөвшөөрлийг ямар хугацаанд эзэмшиж байгаа, эсхүл байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Монголын хуульчдын холбооны гишүүн 2015 онд болсон, Үндсэн хуулийн эрх зүй болон Захиргааны эрх зүйн хорооны гишүүн, Төрийн захиргааны албанд ажиллаж буйтай холбогдуулан 2018 онд гишүүнчлэлийг түр түдгэлзүүлсэн. <b>Хуульчийн гэрчилгээний дугаар № 5164</b></p>
<p><b>4.4</b></p>	<p><b>Байгаа бол магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолны талаарх мэдээлэл</b></p> <p>Суралцаж төгссөн их, дээд сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, эрдмийн зэрэг, цол авсан огноог бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ 2022, БНЭУ, Козикодэ, "Манлайлал 4.0 Менежментийн чиглэлээр, Энэтхэгийн менежментийн институт, Энэтхэгийн техник, эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /ИТЕС/.</li> <li>➤ 2021 - 2022 онд Манлайллын менежмент. Харвардын бизнесийн сургууль, Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Бизнес академи Harvard Manage Mentor</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>➤ 2015 - 2017 онд Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургууль, Хууль зүйн магистр, 2017.05.15. №E20172936</li> <li>➤ 2008 - 2011 онд Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Эрх зүйч, Бакалавр, 2011.05.20. №D201109389</li> <li>➤ 2006 - 2007 АНУ, Денвер, Тейкёо Лоретта Хэйтс Их сургуулийн хэлний бэлтгэл курст суралцаж төгссөн /Teikyo Loretto Heights university/ сертификат</li> <li>➤ 2000 - 2002 онд Шинжлэх ухааны академийн харьяа Улаанбаатар Их сургууль, Утга зохиолын магистр, 2002.04.10. №0278</li> <li>➤ 1996 - 2000 онд Монголын Бурхны шашны их сургууль, Буддын гүн ухаан судлаач, Бакалавр, 2000.10.15. №D2000/9550</li> </ul> <p>Дипломын хуулбарыг хавсаргав.</p>
4.5	<p><b>Сахилгын шийтгэл</b> Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, эсхүл огцорч байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>.....Үгүй.....</p>

**Хавсралт:**

Нэр дэвших тухай хүсэлтэд журмын 5.1.1-д заасан дараах баримт бичгийг хавсаргана:

-төрийн албан хаагчийн анкет;  
-иргэний үнэмлэхийн хуулбар;  
-нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

-эрх зүйн бакалаврын, эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;

-хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт;

-эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласныг нотлох баримт;  
-энэхүү загварт заасан баримт бичиг;  
-холбогдох бусад баримт.

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: Галбаабадраа. ....

Өөрийн нэр: Даваадалай. ....

Гарын үсэг: .....

Он, сар, өдөр: 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр. ....